



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан ДБМБ ХХК-ний “Титэм” зочид буудлын 15/080, Ундецим Ундецим ХХК-ний “Элеганс” Зочид буудлын 13/034, Дэлгэр хур трейд ХХК “Мичид” зочид буудлын 14/57, Мөнх-Оюу ХХК-ний “Анар” зочид буудлын 16/075, Ти Энд Жи ХХК-ний “Нью Вест” зочид буудлын 16/062, Эзэнтөр ХХК-ний “Мөрөн” зочид буудлын 16/121, Номгон гол ХХК-ний “Мөнх Хустай” зочид буудлын 16/082, Эрмон билэг ХХК-ний “Эрмон билэг” дэн буудлын 16/115, Билгүүн Лотус ХХК-ний “Лотус” дэн буудлын 13/135, Монгол цонх Плаза ХХК-ний “Монгол цонх” дэн буудлын 14/004, Хөх тэнгэрийн Заяа ХХК-ний “Доллар” дэн буудлын 16/103, Иргэн Д.Рэгзэдмаа “Филимон” дэн буудлын 16/080, Иргэн

Ц.Чинзоригт "Хан хөхий" дэн буудлын 14/43 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огтонсууд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 11 сарын 07 өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх Оюу ХХК	2560666	Анар	БЗД-ийн 15-р хороо ЭТӨЧ 45
2	Дэлгэр хур трейд ХХК	2858673	Мичид	БГД-ийн 17-р хороо Дамдинбазарын гудамж
3	Үндецим Үндецим ХХК	5429552	Элеганс	ЧД-ийн 4-р хороо Самбуугийн гудамж 16-3
4	ДБМБ ХХК	5637635	Титэм	СХД-ийн 29-р хороо Драгон центр
5	Номгон гол ХХК	2084511	Мөнх хустай	БГД-ийн 4-р хороо ЭТӨЧ-68
6	Ти Энд Жи ХХК	2062496	Нью Вест	БГД-ийн 5-р хороо 10-р хороолол 91-р байр
7	Эзэнтөр ХХК	2034654	Мөрөн	БГД-ийн 8-р хороо Дилав Хутагт Жамсранжавын гудамж 1

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 11 сарын 07
өдрийн 8:31 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ц.Чинзоригт	ШЕ77111832	Хан хөхий	БЗД-ийн 27-р хороо Дунд дарь эхийн 5д
2	Иргэн Д.Рэгзэдмаа	ЧЙ67102108	Филимон	БЗД-ийн 7-р хороо 386
3	Хөх тэнгэрийн Заяа ХХК	5071925	Доллар	СХД-ийн 19-р хороо Үйлдвэрчний эвлэлийн 75
4	Монгол Цонх Плаза ХХК	5370434	Монгол Цонх	БГД-ийн 3-р хороо Замчдын гудамж 6/1
5	Билгүүн Лотус ХХК	5645719	Лотус	БЗД-ийн 16-р хороо 16-р хороолол 49-12
6	Эрмон Билэг ХХК	2585022	Эрмон Билэг	БГД-ийн 17-р хороо Дамдинбазарын гудамж 39

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 11 сарын 07
өдрийн дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Баян харзаг ХХК	5264669	Монде Тур	НД-ийн 6-р хороо Горхи Тэрэлжийн БЦГазар
2	БЗД-ийн Баянзүрх Шижир ҮХӨААТҮГ	8113823	Баянзүрх Шижир	БЗД-ийн 20-р хороо Гацуурт тосгон, Шар хоолой, Шижирийн аманд

--ooOoo--